



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/251

Булган сум

Усны тоо бүртгэл явуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны XII хуралдааны XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн нутаг дэвсгэрт усны тоо бүртгэлийн ажлыг 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс 2026 оны 10 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулсугай.

2.Усны тоо бүртгэлийн ажлыг явуулах зардлын хуваарилалтыг хавсралтаар баталсугай.

3.Усны тоо бүртгэлийн ажилд шаардагдах 9,858,000 (есөн сая найман зуун тавин найман мянга) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлын “Усны нөөц хамгаалах, усан хангамжийг сайжруулах чиглэл”-ийн арга хэмжээнээс санхүүжүүлэхийг Байгаль хамгаалах сангийн Нягтлан бодогч (Б.Очирсүрэн)-д зөвшөөрсүгэй.

4.Хануй, Сэлэнгэ голын сав газрын захиргаадтай Усны тоо бүртгэлийн ажлын гэрээ байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны газрын дарга (А.Гантөмөр)-д, сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, хамтарч ажиллахыг сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР



6326010350

Аймгийн Засаг даргын 2026 оны
08 дүгээр сарын 08-ны/ний өдрийн
А/251 дугаар захирамжийн хавсралт

Усны тоо бүртгэлийн ажлын зардлын хуваарилалт

Д/д	Сав газрын захиргааны нэр	Нийт хуваарилах зардлын хэмжээ (төгрөг)
1	2	3
1	Хануй голын сав газрын захиргаа	6,161,250
2	Сэлэнгэ голын сав газрын захиргаа	3,696,750
	Нийт дүн	9,858,000

--o00o--